

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН 2024 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 12-НЫ ӨДРИЙН ЭЭЛЖИТ
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНӨӨР НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр

Улаанбаатар хот

Д/д	Үүрэг, даалгаврын дагуу хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээгүй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Хувь
Үүрэг, даалгавар ГУРАВ: Дүүргийн төсвөөс нийслэлд төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг биелүүлж, орлогын төлөвлөгөөг тасалдуулсан байгууллагуудад хариуцлага тооцож ажиллах- СТСХ				
1.	Дүүргийн төсвийн орлого 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар өссөн дүнгээр 211,078,208.0 мянган төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөтэйгөөс 194,218,582.0 мянган төгрөгийг төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлт 92%-ийн гүйцэтгэлтэй байна. Тайлант оны татварын өрийг барагдуулахаар 4409 татвар төлөгчийн 272,543,937.4 мянган төгрөгийн нэхэмжлэхийг хүргүүлж, 2711 татвар төлөгчийн 6,673,085.5 мянган төгрөгийг барагдуулсан. Мөн 102,558,782.8 мянган төгрөгийн өртэй 811 татвар төлөгч иргэн, хуулийн этгээдийн данс битүүмжлэх ажиллагааг хийж, 3 хуулийн этгээдийн 292,777.3 мянган төгрөгийн авлагыг битүүмжилсэн.	-	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана.	90%
Үүрэг, даалгавар ЗУРГАА: Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч Дүүргүүдэд хот, нийтийн аж ахуйн машин, тоног төхөөрөмжүүдийг хуваарилж, давс, бодисын нөөцлөлт бэлэн байгаа эсэхэд газар дээр нь очиж, нөхцөл байдалтай танилцах- ТНААХ				
2.	Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Чингэлтэй дүүргийн “Тохижилт үйлчилгээ” ХХК, “Найши трейд” ХХК-уудын 2024-2025 оны өвөлжилтийн бэлтгэл ажилтай танилцсан. Тус ажлын хүрээнд хот нийтийн аж ахуйн чиглэлээр ажиллаж буй дээр байгууллагуудын өвөлжилтийн бэлтгэл ажил бүрэн хангагдсан. ✓ Чингэлтэй дүүргийн Тохижилт үйлчилгээ ХХК: Ажилчдын хувцас хэрэгсэл: Өвлийн нормын хувцас - 300ш, Өвлийн гутал /хос/-300 хос, Бээлий /хос/ - 1000 хос, Түрдэг тэрэг-300 ш, Хүрз-500 ш, Цавчуур-200 ш, Акумлятор-100 ш, Дугуй-100 ш зэрэг ажилчдын хувцас, багаж хэрэгслийг бэлтгэсэн. Машин техник: Давс бодис цацах камаз -11, Цас үлээгчтэй, давс цацагчтай зориулалтын машин-2, Цас ачих зориулалтаар ковш- 2, Грейдэр - 1, Экскаватор -2, Далангийн индүү-1,	-	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана.	100%

	Хог тээвэрлэх шахдаг машин-18, Жижиг самосвол-19, Бусад-31, Авто замын нуух шүүрдэх шүүрдэгч машин-3 нийт 90 техник хэрэгслийн бэлэн байдлыг хангасан. Давс бодис нөөцлөлт: Давс - 1500 тн., Бодис-1500 тн., Хайрга, дайрга - 500 м/куб нөөцөлсөн. ✓ Найши трейд ХХК: Машин техник: Хог тээвэр-16 , Зам шүүрдэгч /жижиг/ -2, Давс цацагч машин 2,5 тн-1, Давс цацагч машин 8 тн-1, Ковш-2, Цас ачих машин-2, Ажилчдын автобус-1 нийт 26 машин техник хэрэгслийн бэлэн байдлыг хангасан. Давс бодис нөөцлөлт: 201 тонн тусгай зориулалтын бодис, 220 тн тусгай зориулалтын давс нөөцөлсөн.			
Үүрэг, даалгавар АРАВ: Дүүргүүд өөрсдийн нутаг дэвсгэр дэх автозамын гүүрэн байгууламжуудын засвар, арчлалтыг хариуцан зохион байгуулах - ТНААХ				
3.	Дүүргийн нутаг дэвсгэр дэх авто замын гүүрэн байгууламжуудын эвдрэл гэмтлийг тогтоох үзлэг шалгалтыг “Чингэлтэй дүүргийн Тохижилт үйлчилгээ” ХХК-тай хамтран 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгуулсан. Уг үзлэг шалгалтаар тус дүүргийн 10 дугаар хороо, 39 дүгээр сургуулийн урд талын авто замын гүүрэн байгууламжийн зорчих хэсэгт их хэмжээний нүхэн эвдрэл үүссэн байсан тул “Чингэлтэй дүүргийн Тохижилт үйлчилгээ” ХХК-аар засварлуулж, дүүргийн урсгал зардлын хөрөнгөөс гүйцэтгэлээр санхүүжүүлэхээр ажиллаж байгаа ба 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр эхлүүлэхээр төлөвлөж байна.	-	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана.	100%
Үүрэг, даалгавар АРВАН ХОЁР: Хог хаягдлыг ангилах ажлыг нэвтрүүлэх. Үүнд: Байшин хороолол дунд суурин буюу газар доор хогийн сав байрлуулах ,гэр хорооллын 2 гудамжны үзүүрт нь хогийн тэвшнүүд байршуулах гэх мэт- ТНААХ				
4.	Дүүргийн 1 болон 21 дүгээр хороонд 18 кв.м талбайд ухаалаг хогийн савыг байршуулсан ба ил харагдах хогийн савны газар дор 3 куб.м-ийн хэмжээтэй 2 том хогийн савыг байрлуулсан. Уг ухаалаг хогийн сав нь хэрэглэхэд хялбар, засвар үйлчилгээ хийхгүйгээр удаан хугацаанд ашиглах боломжтой ба хог хаягдлаас гарах үнэрийг гадагш орчинд нэвтрүүлдэггүй, хогоор дүүрсэн тохиолдолд дүүргийн “Тохижилт үйлчилгээний компани”-д мэдээлэл очиж, хогийг дор бүр нь тээвэрлэх боломжтой юм. Чингэлтэй дүүргийн зүгээс цаашид үе шаттайгаар байшин хороодын хотхон дунд ухаалаг хогийн сав, цэгүүдийг байршуулахаар зураг, төсвийн ажил хийгдэж байгаа ба “Барилга хөгжлийн төв”-ийн магадлалын ерөнхий дүгнэлт гаргуулахаар 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 3/2800 тоот албан бичгээр хүсэлт хүргүүлсэн. Дүүргийн нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн нийт 10 байршилд ухаалаг хогийн савыг байршуулахаар төлөвлөж байна.		Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана.	90%
Үүрэг, даалгавар ХОРИН НЭГ: Нийслэлийн нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, орон сууц, гэр хорооллын гэрэлтүүлэг, кабель, шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг тогтмол хийж, явган замыг стандартад нийцүүлэх ажлыг зохион байгуулж ажиллах- ТНААХ				
5.	Нийслэлийн нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, орон сууц, гэр хорооллын гэрэлтүүлгийн ашиглалт үйлчилгээг “Соёндрийм” ХХК хариуцан ажилладаг ба дүүргийн		Үүрэг даалгаврын	

	1-24 дүгээр хорооны 9707 ш гэрэлтүүлэг, төв замын гэрэлтүүлгийн ашиглалт үйлчилгээг “Энержи комплекс” ХХК 1925 ш гэрэлтүүлгийн засвар үйлчилгээг тогтмол хийж гүйцэтгэж байна. “Соёндрийм” ХХК 2024 оны 11 дүгээр сард 250м сип кабелийн гэмтлийг, “Энержи комплекс” ХХК 120м кабелийн гэмтлийг тус тус засварлаж, хэвийн ажиллагаанд оруулсан. Мөн ашиглалтын шаардлага хангахгүй, эвдэрч муудсан явган замын судалгааг гарган дүүргийн төсвийн хөрөнгөөр 2025 онд хийж гүйцэтгэх тохижилтын ажлын төлөвлөгөөнд нийт 2 багц ажлын саналыг тусгасан.		хэрэгжилт хангагдана.	100%
--	---	--	-----------------------	------

ТАНИЛЦСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Л.БАЯРМАА

НЭГТГЭСЭН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

В.УРАНЧИМЭГ